



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОН

ТАЛ НУТГИЙН ХӨГЖЛИЙН ЗАМ ХХК-ИЙН  
ХООРОНД БАЙГУУЛСАН

“ТАВАНТОЛГОЙ-ГАШУУНСУХАЙТ ЧИГЛЭЛИЙН 250 КМ ХҮНД ДААЦЫН  
ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМ ТӨСӨЛ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗУРАГ ТӨСӨЛ  
БОЛОВСРУУЛАХ-БАРИХ-АШИГЛАХ-ШИЛЖҮҮЛЭХ (DBOT) КОНЦЕССЫН ГЭРЭЭ

2019 ОНЫ 3 ДУГААР САРЫН 29-НИЙ ӨДӨР

## НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Концессын тухай хуулийн 6.2.12, Улсын Их Хурлын 2018 оны “Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 73 дугаар тогтоол, Засгийн газрын 2013 оны “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлах тухай” 317 дугаар тогтооолын 24<sup>15</sup>, Засгийн газрын 2018 оны “Концессын гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай” 229 дүгээр тогтоолуудыг тус тус ҮНДЭСЛЭН:

### НЭГ ТАЛААС

Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газар “цаашид “Эрх бүхий этгээд” гэх”, түүнийг төлөөлж газрын дарга Б.Баярсайхан;

### НӨГӨӨ ТАЛААС

“Тал нутгийн хөгжлийн зам” ХХК “цаашид “Концесс эзэмшигч” гэх”, түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал Б.Болор-Эрдэнэ нар;


“Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто зам төсөл” (энэхүү төслийн авто замын километрийн бодит урт зураг төслөөр эцэслэн баталгаажсан байна.) (цаашид “Төсөл” гэх)-ийг хэрэгжүүлэх “Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх” (DBOT) төрлийн концессын гэрээг (“цаашид “Гэрээ” гэх”) 2019 оны 3 дугаар сарын 29-ний өдөр харилцан тохиролцож энэхүү Гэрээг байгуулав.

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ КОНЦЕССЫН ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

#### Нэр томьёоны тодорхойлолт:

- 1.1. Энэхүү гэрээнд заасан нэр томьёог дараах утгаар ойлгоно. Үүнд:
  - 1.1.1. Эрх бүхий этгээд гэж концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг;
  - 1.1.2. Зохицуулах байгууллага гэж концессыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл олгох, үнэ тариф тогтоох, концессын зүйл, эсхүл түүгээр үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон дүрэм, журмыг батлах, мөрдүүлэх үүрэг бүхий төрийн байгууллагыг;
  - 1.1.3. Концесс эзэмшигч гэж “Тал нутгийн хөгжлийн зам” ХХК-ийг;
  - 1.1.4. Концессыг санхүүжүүлэгч гэж Концесс эзэмшигчийн үйл ажиллагаанд зориулан зээл олгох, баталгаа гаргах зэрэг санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч этгээдийг;
  - 1.1.5. Төслийн нийт хөрөнгө оруулалт гэж Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто зам, түүний дагалдах байгууламжийг барьж байгуулахад оруулсан бүхий л хөрөнгө, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ, гаргасан зардлыг ойлгоно.

Үүнд; технологи, өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгө болон авто замын зураг төсөл, төлөвлөгөө, хийгдсэн ажлууд, засвар арчлалтын зардал, санхүүжилтийн зээл, санхүүгийн зардал, төслийн менежментийн зардал гэх мэт;



- 1.1.6. Концессын гэрээ гэж Эрх бүхий этгээд болон Концесс эзэмшигч нарын хооронд бичгээр байгуулсан Энэхүү гэрээг;
- 1.1.7. Талууд гэж Эрх бүхий этгээд болон Концесс эзэмшигчийг хамтад нь;
- 1.1.8. Барилгын ажил гүйцэтгэгч гэж Концесс эзэмшигчтэй гэрээ байгуулсаны үндсэн дээр барилгын ажлыг гүйцэтгэх эрх бүхий хуулийн этгээдийг;
- 1.1.9. Давагдашгүй хүчин зүйл гэж газар хөдлөлт, хүчтэй салхи, түймэр, аянга, үер, ган зэрэг байгалийн гамшиг, цацраг идэвхт бодисын хордуулалт, олон улсын шинжтэй хилийн боомт хаагдах /аль нэг талдаа/, хөдөлмөрийн маргаанаас үүдсэн өргөн хэмжээний эмх замбараагүй байдал, тахал, дайн, дайн бүхий байдал, хорио цээр зэрэг нийгмийн онцгой байдал зэрэг энэхүү Гэрээний аль нэг талын хяналтаас давсан үйлдлийг.

#### **Гэрээний тайлбар:**

- 1.2. Энэхүү Гэрээнд талууд гарын үсэг зурснаар гэрээ байгуулагдсанд тооцогдох ба Гэрээний 1.34-т заасан урьдчилсан нөхцөл бүрэн хангагдсан талаар дүгнэлт гарсан өдрөөс эхлэн энэхүү Гэрээ хүчин төгөлдөр болно.
- 1.3. Энэхүү Гэрээний гарчиг нь зөвхөн хэрэглэхэд ойлгомжтой болгох зорилготой бөгөөд гэрээний агуулгыг тайлбарлахад нөлөөлөхгүй.

#### **Концессын зүйл:**


- 1.4. Энэхүү гэрээний концессын зүйл нь дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:
  - 1.4.1. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто зам, түүний дагалдах байгууламж /цаашид “Авто зам” гэх/;
  - 1.4.2. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто замын батлагдсан зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл, технологийн бичиг баримт, ашиглалтын зааварчилгаа;
  - 1.4.3. Төслийн авто зам дагуух үйлчилгээний байгууламж;
  - 1.4.4. Төлбөр хураах пост, тэдгээрийн өмчлөх эрх, дагалдах байгууламж,
  - 1.4.5. Концессын зүйлийг зориулалтын дагуу ашигласны үр дүнд олж авсан биет хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, тэдгээрийн эрх;
  - 1.4.6. Оюуны өмч, Ноу-хая.

#### **Концессын төрөл:**

- 1.5. Энэхүү Гэрээ нь концессын “Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх” төрөлтэй байна.

#### **Гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээ:**

- 1.6. Концесс эзэмшигч нь энэхүү Гэрээний хугацаанд өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр дараах ажлуудыг гүйцэтгэж, үйлчилгээ үзүүлнэ. Үүнд:
  - 1.6.1. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто замын зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж батлуулах;
  - 1.6.2. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто замыг барьж, ашиглах;
  - 1.6.3. Авто замын засвар, арчлалтыг гүйцэтгэх, тээврийн хэрэгслийг гэрээний дагуу саадгүй зорчих нөхцөл боломжоор хангах;



1.6.4. Энэхүү Гэрээнд заасны дагуу концессын зүйлийг Эрх бүхий этгээдэд шилжүүлэх.

#### Авто замын зориулалт чиглэл:

- 1.7. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто замаар зөвхөн Тавантолгойгоос Гашуунсухайтын боомт руу чиглэх ачаатай тээврийн хэрэгслүүд зорчино.
- 1.8. "Эрдэнэс Монгол" ХХК-ийн өмчлөлийн Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлийн авто замаар зөвхөн Гашуунсухайтын боомтоос Тавантолгой уруу чиглэх тээврийн хэрэгслүүд зорчино.
- 1.9. Концесс эзэмшигч нь энэхүү Гэрээний 1.8-д заасан буцах авто замын төлбөрийг шинээр баригдах авто замаар тээвэрлэх ачааны хэмжээгээр одоогийн Ухаахудаг-Гашуунсухайтын авто замд мөрдөгдөж байгаа хураамжийн тарифыг бууруулахгүй нөхцөлөөр хурааж "Эрдэнэс монгол" ХХК-д хураамжийг шилжүүлэх хамтран ажиллах гэрээг "Эрдэнэс Монгол" ХХК-тай байгуулж ажиллана.
- 1.10. Энэхүү гэрээний 1.9-д заасан хамтран ажиллах гэрээг концессын гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш календарийн 30 хоногийн дотор байгуулна.
- 1.11. Энэхүү гэрээний 1.9-д заасан хамтран ажиллах гэрээний хугацаа нь концессын зүйлийг төрд шилжүүлэх хүртэлх хугацаанд хүчинтэй байна.
- 1.12. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто зам болон Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлийн авто замын аль нэгээр авто тээврийн хэрэгсэл зорчих боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд тухайн нөхцөл байдлыг арилтал энэхүү гэрээний 1.7, 1.8-д заасан чиглэл хамаарахгүй бөгөөд авто замын зорчих боломжтой хэсгээр тээврийн хэрэгслүүдийг нэвтрүүлнэ.

#### Төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилт:

- 1.13. Концесс эзэмшигч нь Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто зам төслийг өөрийн болон өөрийн боломжкоор олсон хөрөнгөөр бүрэн санхүүжүүлнэ.
- 1.14. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто зам төслийн нийт хөрөнгө оруулалт нь 412 633 000 /дөрвөн зуун арван хоёр сая зургаан зуун гучин гурван мянган/ ам доллартай тэнцэх төгрөгөөс ихгүй байна.
- 1.15. Энэхүү төсөлд Засгийн газрын зүгээс санхүүгийн дэмжлэг үзүүлэхгүй бөгөөд төлбөрийн болон орлогын аливаа баталгаа гаргахгүй.

#### Авто замыг ашиглалтад оруулах хугацаа, гүйцэтгэлийн баталгаа:

- 1.16. Концесс эзэмшигч нь Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто замыг энэхүү Гэрээ хүчин төгөлдөр болсон тухай Эрх бүхий этгээдээс мэдэгдэл хүлээн авсан өдрөөс хойш 2.5 жилийн дотор барьж дуусган, ашиглалтад оруулсан байна.
- 1.17. Концесс эзэмшигч нь энэхүү Гэрээний 1.16-д заасан хугацаанд авто замыг ашиглалтад оруулахаа баталж энэхүү Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор 1 /нэг/ тэрбум төгрөгийн авто замын барилгын ажлын гүйцэтгэлийн баталгааг Монгол Улсын аль нэг арилжааны банкнаас 3 жилийн хугацаатайгаар гаргуулан Эрх бүхий этгээдэд ирүүлнэ.



- 1.18. Концесс эзэмшигч нь энэхүү Гэрээний 1.16-д заасан хугацаанд авто замыг ашиглалтад оруулж чадаагүй тохиолдолд энэхүү Гэрээний 1.17-д заасан гүйцэтгэлийн баталгаа нь үл маргах журмаар Эрх бүхий этгээдийн заасан дансанд шилжих бөгөөд энэ талаар тухайн баталгааг гаргасан банкинд төлбөрийг шилжүүлэх мэдэгдэлийг дансны дугаарын хамт Эрх бүхий этгээд хүргүүлнэ.
- 1.19. Энэхүү Гэрээний 1.16-д заасан хугацааны дотор төслийн авто замын барилгын ажил дусаж, улсын комиссын актаар баталгаажсан өдрөөс хойш 30 хоногийн дотор энэхүү Гэрээний 1.17-д заасан гүйцэтгэлийн баталгааг чөлөөлөх мэдэгдлийг Эрх бүхий этгээд нь концесс эзэмшигч болон тухайн баталгааг гаргасан банкинд хүргүүлнэ.

#### **Концессын гэрээний хугацаа:**

- 1.20. Энэхүү гэрээ байгуулагдсан өдрөөс хойш концессын гэрээний хугацаа 14.5 жил байна.
- 1.21. Авто замын барилгын ажлын хугацаа энэхүү Гэрээ хүчин төгөлдөр болсон тухай Эрх бүхий этгээдээс мэдэгдэл гарсан өдрөөс хойш 2.5 жил байна.
- 1.22. Концессын зүйлийг ашиглах хугацаа авто замыг ашиглаж эхэлсэн өдрөөс хойш 12 жил байна.
- 1.23. Энэхүү Гэрээний гэрээ хүчин төгөлдөр болох нөхцөлийг биелүүлэх хугацаа гэрээ байгуулагдсан өдрөөс хойш 6 сар байна.
- 1.24. Энэхүү төслийн ашиглалтын хугацааг тооцож эхэлсэн өдрөөс хойш тээвэрлэсэн ачааны нийт хэмжээ 290 466 000 /хоёр зуун ерэн сая дөрвөн зуун жаран зургаан мянган/ тонн-д хүрч, төсөлд оруулсан хөрөнгө оруулалт, ашигаа концесс эзэмшигч нь нөхсөн тохиолдолд энэхүү гэрээний 1.20-д заасан хугацаа дуусгавар болж концессын зүйл төрд үнэ төлбөргүй шилжинэ.

#### **Төслийн байршил:**

- 1.25. Өмнөговь аймгийн Цогцэций, Баян-Овоо, Ханбогд сумын нутаг дэвсгэрт буюу төслийн авто замын газар зүйн солбицлын эхлэлтийн цэг: хойд 4839444.334, Зүүн 533325.0251, төгсгөлийн цэгийн солбицол: хойд 4707493.365, зүүн 706858.4674 байна.

#### **Концессын гэрээний үндсэн дээр баригдсан авто замаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс авах төлбөрийн хэмжээ:**

- 1.26. Концесс эзэмшигч нь Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто замыг ашиглалтад оруулсан өдрөөс хойш энэхүү Гэрээний хугацаанд концессын зүйлийг ашиглах, засвар арчлалтыг хариуцах, хөрөнгө оруулалтын зардлаа нөхөх зорилгоор авто замаар зорчих тээврийн хэрэгслээс авто зам ашигласны төлбөр хураах эрхийг здэлнэ.
- 1.27. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто зам ашигласны төлбөр нь ачаа /нүүрс, зэс болон бусад ашигт малтмал/ тээвэрлэсэн хүнд даацын автомашины нэг тонн ачаа тутамд 3.4 ам доллартой тэнцэх төгрөгөөс илүүгүй байна.
- 1.28. Энэхүү гэрээний 1.26-д заасан 1, 2 дугаар улиралд хураах төлбөрийг тухайн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрийн, 3, 4 дүгээр улиралд хураах төлбөрийг тухайн жилийн 6 дугаар сарын 30-ны өдрийн Монгол банкны зарласан ханшаар тооцож төгрөгт хөрвүүлж тээврийн хэрэгслээс хураах бөгөөд концесс эзэмшигч нь энэхүү ханшыг тухайн жилдээ мөрдөж ажиллана.



- 1.29.. Авто замыг ашиглаж эхэлсэн өдрөөс хойш эхний 6 жилд энэхүү гэрээний 1.26-д заасан төлбөр тогтвортой байна.
- 1.30.. Авто замыг ашиглаж эхэлсэн өдрөөс хойш 7 дахь жилээс талууд гэрээний хэрэгжилт зохицуулалт хийх хугацаа болон төлбөрийн стандартын талаар хамтарсан дүгнэлт гаргана. 6 дахь жилийн эцэст санхүүгийн загвараар тооцоолсон нийт орлогын хэмжээнд хүрээгүй нөхцөлд өөрчлөлт оруулна. Өөрчлөлтийн хэмжээ нь төлбөр хураан авсан анхны өдрөөс 6 дахь жилийн эцсийн орлогын нийт хэмжээ болон санхүүгийн загвараар урьдчилсан тооцоолсон өмнөх 6 жилийн орлогын нийт хэмжээний зөрүүнд тулгуурлана.
- 1.31.. Концесс эзэмшигч энэхүү гэрээний 1.27-д заасан төлбөрийг нэмэгдүүлэх талаар холбогдох хууль тогтоомжид заасны дагуу үндэслэл бүхий саналыг Эрх бүхий этгээдэд тавьж болох бөгөөд уг саналыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.
- 1.32.. Төслийн авто замаар нийтийн болон хувийн тээврийн том, жижиг тэрэг зорчихтой холбоотой төлбөрийн асуудлыг концесс эзэмшигч нь авто тээврийн асуудал эрхэлсэн териин захиргааны байгууллагатай холбогдох хууль тогтоомжийн дагуу харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 1.33.. Энэхүү Гэрээний үндсэн дээр баригдсан авто замаар зорчих дараах тээврийн хэрэгслүүд төлбөрөөс чөлөөлөгднө. Үүнд:
- 1.33.1. Төрийн тусгай алба;
  - 1.33.2. Түргэн тусламж;
  - 1.33.3. Цагдаагийн алба;
  - 1.33.4. Онцгой байдлын өрөнхий газар;
  - 1.33.5. Аврах ангиуд;
  - 1.33.6. Гал унтраах тээврийн хэрэгслүүд;
  - 1.33.7. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн эзэмшлийн хяналтын авто тээврийн хэрэгслүүд.

#### **Концессын гэрээ хүчин төгөлдөр болох урьдчилсан нөхцөл:**

- 1.34.. Энэхүү Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга дарснаар Гэрээ байгуулагдсанд тооцогдох бөгөөд энэхүү Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш 6 сарын дотор доорх урьдчилсан нөхцөлүүд бүрэн биелэгдэж холбогдох нотлох баримтыг Эрх бүхий этгээдэд ирүүлснээр Гэрээ хүчин төгөлдөр болно. Үүнд:
- 1.34.1. Төслийн санхүүжилтийн гэрээг байгуулсан байх;
  - 1.34.2. Энэхүү Гэрээний 1.14-т заасан төслийн нийт хөрөнгө оруулалтын 10 хувьтай тэнцэх ам долларыг концесс эзэмшигчийн Монгол Улсын арилжааны банкин дахь өөрийн дансанд байршуулсан нотлох баримтыг ирүүлсэн байх;
  - 1.34.3. Авто замын зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулсан байх;
  - 1.34.4. Авто замын барилгын ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан байх;
  - 1.34.5. Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий этгээдтэй зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулсан байх;
  - 1.34.6. Авто замын барилгын ажлыг хийж гүйцэтгэх график төлөвлөгөөг боловсруулж батлуулах;
  - 1.34.7. Авто замын засвар, арчлалтын төлөвлөгөөг боловсруулж батлуулах;
  - 1.34.8. Төслийг хэрэгжүүлэх компанийн гэрчилгээ, дүрэм, хувьцаа эзэмшигчдийн гэрээг байгуулсан байх;



- 1.34.9. Учирч болзошгүй аюул, байгалийн гамшигаас урьдчилан сэргийлэх, хор хохирлыг багасгах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан эрх бүхий байгууллагаар батлуулсан байх;
- 1.34.10. Үйлдвэрлэлийн осол, сүйрлийн үед хүний амь, эд хөрөнгийг авран хамгаалах, болзошгүй гал, ослын үед авран хамгаалах, гал унтраах ажиллагааг явуулахад бэлэн байдлыг хангах төлөвлөгөөг боловсруулж Зохицуулах байгууллагаар батлуулсан байх.
- 1.35. Концесс эзэмшигч нь энэхүү Гэрээний 1.34-т заасан урьдчилсан нөхцөлүүдийг биелүүлэхээ баталж 1 /нэг/ тэрбум төгрөгийн санхүүгийн хаалтын гүйцэтгэлийн баталгааг энэхүү Гэрээг байгуулахаас өмнө Монгол Улсын аль нэг арилжааны банкнаас 9 сарын хугацаатайгаар гаргуулж Эрх бүхий этгээдэд ирүүлсэн байна.
- 1.36. Эрх бүхий этгээд нь энэхүү Гэрээний 1.34, 1.35-д заасан урьдчилсан нөхцөл хангагдсан эсэх талаар дүгнэлт гаргана.
- 1.37. Энэхүү Гэрээний 1.35-д заасан дүгнэлт нь хангалтгүй буюу гэрээний 1.34, 1.35-д заасан нөхцөл биелэгдээгүй тохиолдолд Эрх бүхий этгээд нь энэхүү гэрээг дангаар цуцлах эрхтэй.
- 1.38. Энэхүү Гэрээний 1.37-д заасан үндэслэлээр гэрээ цуцлагдсантай холбогдуулан концесс эзэмшигчид ямар нэгэн нөхөх олговор, хохирлыг, Эрх бүхий этгээд, Засгийн газраас олгохгүй.
- 1.39. Концесс эзэмшигч нь энэхүү Гэрээний 1.34-т заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд энэхүү Гэрээг цуцалж Гэрээний 1.35-д заасан санхүүгийн хаалтын баталгаа болох 1 /нэг/ тэрбум төгрөг үл маргах журмаар Эрх бүхий этгээдийн заасан дансанд шилжүүлэх бөгөөд энэ талаар концесс эзэмшигч маргаан үүсгэх эрхгүй байна.
- 1.40. Эрх бүхий этгээд болон Зохицуулах байгууллагатай холбоотойгоор энэхүү Гэрээний 1.34-т заасан нөхцөлүүд биелэгдэх боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд энэхүү Гэрээ хүчин төгөлдөр болох хугацааг концесс эзэмшигчтэй тохиролцон боломжит хугацаагаар сунгаж болно.
- 1.41. Энэхүү Гэрээний 1.34-т заасан гэрээний урьдчилсан нөхцөл хангагдсан өдрөөс хойш энэхүү Гэрээний 1.35-д заасан санхүүгийн хаалтын баталгааг концесс эзэмшигч нь буцаан авах эрхтэй бөгөөд Эрх бүхий этгээд нь 30 хоногийн дотор буцаан шилжүүлнэ.

### ХОЁРДУГААР БҮЛЭГ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД, ЗОХИЦУУЛАХ БАЙГУУЛЛАГА, КОНЦЕСС ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

**Эрх бүхий этгээдийн эрх, үүрэг:**

- 2.1. Төслийн хэрэгжилттэй холбогдуулан концесс эзэмшигчийг зохицуулах байгууллагуудтай хамтран ажиллахад нь бодит дэмжлэг үзүүлнэ.
- 2.2. Эрх бүхий этгээд нь гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийх, хяналт тавих эрхтэй.
- 2.3. Төслийн үйл явцтай газар дээр нь очиж танилцах эрхтэй.
- 2.4. Концесс эзэмшигчийг энэхүү Гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.
- 2.5. Эрх бүхий этгээд болон Зохицуулах байгууллага нь энэхүү Гэрээний 1.34-т заасан нөхцөлүүдийг концесс эзэмшигч биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.
- 2.6. Концесс эзэмшигчээс улирал бүр санхүүгийн тайлан, концессын гэрээний гүйцэтгэлийн тайлан мэдээг гаргуулж авах эрхтэй.
- 2.7. Шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу төслийн санхүүжилтийн гэрээг концесс эзэмшигч, төслийг санхүүжүүлэгчтэй хамтран байгуулж

УХА0588  
6098177  
1116127253

- болов ба энэ тохиолдолд Эрх бүхий этгээд нь ямар нэгэн санхүүгийн хариуцлага хүлээхгүй.
- 2.8. Гэрээний хугацаанд Эрх бүхий этгээд нь гуравдагч этгээдэд төслийн авто замын 2 талын зурvas газар тус бүрээс 50 км зай бүхий бүсэд аливаа зэрэгцээ авто зам шинээр барих зөвшөөрлийг олгохгүй.
  - 2.9. Монгол Улсын Засгийн газар нь “Тавантолгой-Гашуунсуухайт чиглэлийн төмөр зам төсөл”-ийг барихтай холбогдуулан шийдвэр гаргах, төслийг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй болно.
  - 2.10. Эрх бүхий этгээд концессын эрхийн аливаа нэг хэсгийг гэрээнд зааснаас бусад тохиолдолд гэрээний хугацаанд бусдад дахин олгохгүй.
  - 2.11. Концесс эзэмшигчээс концессын төсөлтэй холбоотой гаргасан аливаа хүсэлт, мэдэгдлийг Эрх бүхий этгээд хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянан үзэж хариу мэдэгдлийг хүргүүлнэ.
  - 2.12. Эрх бүхий этгээд нь энэхүү Гэрээг Монгол Улсын Засгийн газраас баталгаажуулсан тогтоолын хуулбарын хамт концесс эзэмшигчид өгөх.
  - 2.13. Энэхүү Гэрээний урьдчилсан нөхцөл биелүүлэх хугацаанд Засгийн газар, Эрх бүхий этгээд үндэслэлгүйгээр энэхүү Гэрээг цуцлах шийдвэр гаргавал концесс эзэмшигчийн боловсруулж, батлуулсан зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэлийг зохиогчийн эрхийн хамт Эрх бүхий этгээд худалдаж авна. Мөн концесс эзэмшигчид учирсан бодит хохирол, зардлыг алдангийн хамт хариуцан төлнө.
  - 2.14. Эрх бүхий этгээд нь тухайн орон нутгийн засаг захиргаа, эрх бүхий зохицуулах байгууллагуудтай хамтран ажиллаж авто зам, түүний барилга байгууламжийг барихад шаардлагатай газрыг ашиглахад нь дэмжлэг үзүүлнэ.
  - 2.15. Концесс эзэмшигчийн гүйцэтгэсэн төслийн авто замын барилгын ажлыг хүлээн авсан тухай комиссын актын хуулбар хувийг Эрх бүхий этгээдэд нь холбогдох зохицуулах байгууллагуудад хүргэх.
  - 2.16. Эрх бүхий байгууллага эсвэл зохицуулах байгууллага шаардсаны улмаас зураг төсөлд өөрчлөлт оруулснаас үсэх үр дагаврыг Эрх бүхий байгууллага эсвэл Зохицуулах байгууллага хариуцлага хүлээнэ.
  - 2.17. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

#### **Зохицуулах байгууллагуудын эрх, үүрэг:**

- 2.18. Концесс эзэмшигчид төслийг хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан шаардлагатай зөвшөөрлүүдийг холбогдох хууль тогтоомжийн дагуу саадгүй олгох.
- 2.19. Авто замын барилгын ажлын зургийн даалгаврыг боловсруулж концесс эзэмшигчид хүлээлгэн өгөх.
- 2.20. Концесс эзэмшигчийн өөрийн хөрөнгөөр боловсруулсан зургийн ажлын даалгаврыг батлах, магадлал хийх.
- 2.21. Авто зам, замын байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх тусгай болон барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийг холбогдох хуульд заасны дагуу олгох.
- 2.22. Төслийн үйл ажиллагаанд оролцох гадаадын инженер техникийн болон мэргэшсэн ажилчдын ажил эрхлэх зөвшөөрлийг хуульд заасны дагуу олгох.
- 2.23. Төслийн авто зам тавихад ашиглагдах түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах зөвшөөрлийг хуульд заасан нөхцөл журмын дагуу олгоно.
- 2.24. Хууль болон энэхүү Гэрээнд өөрөөр заагаагүй бол Зохицуулах байгууллага нь аливаа зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл олгоходо үндэслэлгүйгээр удаашруулж, саатуулж болохгүй бөгөөд хэрэв ийм тохиолдол тулгарсан бол хууль зүйн үндэслэлтэйгээр, шударгаар хандан шийдвэрлэнэ.

УХА0588  
6098177  
1116127253

2.25. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

**Концесс эзэмшигчийн эрх, үүрэг:**

- 2.26. Концесс эзэмшигч нь энэхүү төслийг хэрэгжүүлэхээр байгуулагдсан, Монгол Улсад бүртгэгдсэн концессын онцгой эрхийг хэрэгжүүлэх төслийн компани бөгөөд төсөлтэй холбоогүй аливаа үүрэг, хариуцлага хүлээхгүй болно.
- 2.27. Төслийг өөрийн болон концесс санхүүжүүлэгчийн хөрөнгөөр санхүүжүүлэн санхүүгийн эрсдэлээ 100 хувь концесс эзэмшигч өөрөө хариуцана.
- 2.28. Концесс эзэмшигч нь төслийн хүрээнд хөрөнгө оруулалтаа захиран зарцуулах, хууль ёсны ашиг, орлогоо гадаадад шилжүүлэх, гадаадаас шилжүүлэн авах эрхтэй.
- 2.29. Авто замыг холбогдох дүрэм, журам, норм стандартын дагуу Энэхүү гэрээний 1.16-д заасан хугацаанд барьж дуусгах, улсын комисст хүлээлгэн өгөх, ашиглалтад оруулах.
- 2.30. Концессын гэрээний хугацаанд авто замын засвар, арчлалтыг хариуцах.
- 2.31. Концесс эзэмшигчид концессын төслийн зам дагуу заасан талбайд үйлчилгээний зориулалттай байгууламж барих, түүнийг ашиглах, ашиг хүртэх эрхтэй.
- 2.32. Эрх бүхий этгээдийн өмнө Концессын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.4-т заасан нийтлэг эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ.
- 2.33. Концессын зүйлийг төрд шилжүүлэхээс 1 жилийн өмнө байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх үүднээс авто замыг ослын даатгалд даатгуулсан байх бөгөөд даатгалын гэрээг ажлын 5 хоногийн дотор концесс эзэмшигч нь Эрх бүхий этгээдэд ирүүлсэн байна.
- 2.34. Концессын гэрээний хугацаа дуусгавар болоход Концесс эзэмшигч нь концессын зүйлийг үнэ төлбөргүйгээр Эрх бүхий этгээдэд шилжүүлнэ. Үүнд:
- 2.34.1. Концесс эзэмшигч нь энэхүү Гэрээний хугацаа дуусгавар болохос 12 сарын өмнө концессын зүйлийг шилжүүлэх төлөвлөгөөг боловсруулан баталж Эрх бүхий этгээд хүргүүлэхдээ санхүүгийн өр төлбөргүй байхаар;
- 2.34.2. Энэхүү Гэрээний хугацаа дуусгавар болохос 1 жилийн өмнө авто замд өөрийн хөрөнгөөр их засварыг хийж, шилжүүлэн өгөх шаардлага хангасан эсэхэд холбогдох байгууллагаар дүгнэлт гаргуулах.
- 2.35. Эрх бүхий этгээд, Зохицуулах байгууллагыг энэхүү Гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах.
- 2.36. Концесс эзэмшигч нь энэхүү Гэрээг хэрэгжүүлэх хугацаанд хөрөнгө оруулалт болон ашгаа нөхөж чадахгүйг урьдчилан тооцоолбол энэхүү Гэрээний хугацаа дуусахаас 12 сарын өмнө Эрх бүхий этгээдэд хүсэлтээ тавих эрхтэй.
- 2.37. Жил бүрийн I улиралд багтаан өнгөрсөн оны аудитаар баталгаажуулагдсан санхүүгийн тайланг Эрх бүхий этгээдэд ирүүлэх үүрэгтэй.
- 2.38. Концесс эзэмшигч нь концессын зүйлийн ашиглалтын хэвийн нөхцөл, найдвартай үйл ажиллагааг хангах, элэгдэл эвдрэлээс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор засвар үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулж, энэхүү төслийн хэвийн үйл ажиллагааг хангана.
- 2.39. Энэхүү Гэрээний хугацаанд ачаатай тээвэрлэлтийн хэмжээ гэрээний 1.24-т заасан тоо хэмжээнд хүрээгүй, 1.14-т заасан хөрөнгө оруулалтаа нөхөөгүй бол шаардлагатай хугацаагаар концесс эзэмшигч нь ашиглалтын хугацааг сунгах саналаа Эрх бүхий этгээдэд тавих эрхтэй.
- 2.40. Концесс эзэмшигч нь энэхүү Гэрээний нийт хугацаанд концессын зүйлийг барих, ашиглах, засвар арчлалтын үйлчилгээг үзүүлэх, ашиглахаас гадна дараах онцгой

УХА0588  
6098177  
1116127253

эрхтэй..Үүнд:

- 2.40.1. Барилгын ажлын менежментийн эрх (үүнд: туслан гүйцэтгэх, хяналт, зураг төсөл, худалдан авах зэрэг энэхүү төслийн барилгатай холбоотой бүхий ажлууд);
- 2.40.2. Ашиглалтын менежментийн эрх болон тээврийн хэрэгслээс зам ашигласны төлбөр авах эрх;
- 2.40.3. Үйлчилгээний хэсгийн үйлчилгээний байгууламжийг барих, ашиглах менежментийн эрх.

#### Концесс эзэмшигчид хориглох зүйл:

- 2.41. Концесс эзэмшигч нь Эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Үүнд:
  - 2.41.1. Концессын зүйлийг арилжих, худалдах, Эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлэх;
  - 2.41.2. Концессыг хэрэгжүүлэх санхүүжилтийг олох зорилгоос бусад зорилгоор концессын зүйлийг барьцаалах;
  - 2.41.3. Концессын зүйлээр баталгаа гаргах;
  - 2.41.4. Ирээдүйд олох ашгаа барьцаалж зах зээлээс хөрөнгө босгох;
  - 2.41.5. Төслийн компанийн хувьцаа эзэмшигчдийг өөрчлөх;
  - 2.41.6. Аливаа бусад эрх, үүргээ бусдад шилжүүлэх.


#### Концессыг санхүүжүүлэгчийн эрх:

- 2.42. Концессыг санхүүжүүлэгч нь дараах эрх эдэлнэ. Үүнд:
  - 2.42.1. Концесс эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавих;
  - 2.42.2. концессын зүйл, түүний барилга байгууламжид нэвтрэх;
  - 2.42.3. Концесс эзэмшигчийн барьцаалсан эд хөрөнгө, эрхийг хууль тогтоомж болон холбогдох гэрээнд заасан журмын дагуу өөртөө шилжүүлэн авах;
  - 2.42.4. Концесс эзэмшигч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй, Концесс эзэмшигч дампуурсан буюу татан буугдсан тохиолдолд концессын гэрээнд заасан журмын дагуу Эрх бүхий этгээдийн зөвшөөрлөөр концессын зүйлийг удирдах, өөр этгээдэд концессын зүйлийг шилжүүлэх саналыг Эрх бүхий этгээдэд тавих.

### ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЗУРАГ ТӨСӨЛ, БАРИЛГЫН АЖИЛ, ЗАСВАР АРЧЛАЛТ, ШИЛЖҮҮЛЭН ӨГӨХ ТӨЛӨВЛӨГӨӨ

#### Авто зам, замын байгууламжийн зураг төсөл, төлөвлөлт, барилгын ажил

- 3.1. Концесс эзэмшигч авто замын зураг төслийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр хийж гүйцэтгэн, эрх бүхий байгууллагаар батлуулна.
- 3.2. Концесс эзэмшигч нь авто замын зураг төслийг мэргэжлийн тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээр гүйцэтгүүлсэн байна.
- 3.3. Төслийн барилгын ажлын зургийн даалгаврыг холбогдох төрийн захиргааны эрх бүхий байгууллага гаргаж өгнө.
- 3.4. Концесс эзэмшигч нь төслийн барилгын ажлыг энэхүү Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор эхлүүлсэн байна.



- 3.5. Концесс эзэмшигч нь төслийн барилгыг батлагдсан зураг төслийн дагуу барьж дуусгана.
- 3.6. Концесс эзэмшигч нь төслийн авто замын барилга угсралтын ажил дуусмагц улсын комисс ажиллуулж ашиглалтад оруулах эрхээ олж авна.
- 3.7. Концесс эзэмшигч нь төслийн барилгын ажлын гуравны нэгээс доошгүй хувийг үндэсний аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлнэ.

#### **Засвар арчлалт, saatuuлах сан:**

- 3.8. Концесс эзэмшигч нь Энэхүү гэрээний хугацаанд төслийн барилгын засвар арчлалтыг өөрөө бүрэн хариуцна.
- 3.9. Концесс эзэмшигч нь Концессын гэрээний хугацаа дуусахаас 1 жилийн өмнө авто замд өөрийн хөрөнгөөр их засвар хийсэн байна.
- 3.10. Эрх бүхий этгээд болон концесс эзэмшигч нь энэхүү гэрээний 3.9-д заасан нөхцөлийг хангуулах зорилгоор энэхүү гэрээний хугацаа дуусахаас 2 жилийн өмнө дундын saatuuлах санг байгуулна.
- 3.11. Энэхүү saatuuлах санд байршуулах хөрөнгө нь их засварын өртгийн хэмжээтэй тэнцуу байна.
- 3.12. Концесс эзэмшигч нь saatuuлах санг байгуулсан өдрөөс хойш 2 сарын дотор их засварын өртгийг тооцоолон боловсруулж холбогдох төрийн захиргааны байгууллагаар магадлал хийлгэнэ.
- 3.13. Магадлалаар баталгаажсан үнийн дүнг Концесс эзэмшигч нь дундын saatuuлах дансанд 1 сарын дотор байршуулсан байна.
- 3.14. Хэрэв концесс эзэмшигч нь Эрх бүхий этгээдийн шаардсан засвар үйлчилгээ хийх ажлыг хангалттай хэмжээнд гүйцэтгэсэн, тухайн ажлын бүх зардлыг концесс эзэмшигч төлсөн бөгөөд энэхүү Гэрээг цуцлах тухай аливаа мэдэгдэл хүлээн аваагүй бол, Эрх бүхий этгээд Саатуулах сангийн дансанд байгаа үлдэгдлийг концесс эзэмшигчид шилжүүлнэ.
- 3.15. Концесс эзэмшигч нь Ухаахудаг-Гашуусухайт чиглэлийн авто замын Гашуусухайт боомтоос Тавантолгой руу буцах авто замын засвар үйлчилгээг хариуцахгүй.

#### **Шилжүүлэн өгөх төлөвлөгөө:**

- 3.16. Концесс эзэмшигч нь концессын зүйлийг шилжүүлэн өгөх төлөвлөгөөг боловсруулна.
- 3.17. Концесс эзэмшигч нь Энэхүү гэрээний хугацаа дуусгавар болоход ямар нэгэн биет байдлын болон эрхийн догондолгуй концессын зүйлийг Эрх бүхий этгээдэд үнэ төлбөргүй шилжүүлэн өгнө.
- 3.18. Концесс эзэмшигч нь концессын зүйлийг ашиглалтад оруулахаар тайлан гаргаж хүргүүлснээр хойш Эрх бүхий этгээд нь холбогдох төрийн захиргааны байгууллагын төлөөллийг оролцуулан концессын зүйлийг хүлээн авах комиссыг 30 хоногийн дотор байгуулна.
- 3.19. Концесс эзэмшигч нь засвар үйлчилгээ хийсэн тухай бүртгэлийг хөтөлж, Эрх бүхий этгээд, Зохицуулах байгууллагад хүргүүлж, нээлттэй байлгана.
- 3.20. Концесс эзэмшигч нь концессын зүйлийн ашиглалтын хэвийн нөхцөл, найдвартай үйл ажиллагааг хангах, элэгдэл, эвдрэлээс хамгаалах, шаардлагатай засвар шинэчлэлтийг төлөвлөгөөний дагуу цаг тухай бүрд хийх үүрэг хүлээнэ.
- 3.21. Концесс эзэмшигч нь авто замын барилгын ажлыг дуусган авто замыг ашиглалтад оруулах хүснэгтээ Эрх бүхий этгээд болон Зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

УХА0588  
6098177  
1116127253

- 3.22. Концесс эзэмшигч нь авто замыг шилжүүлэн өгөх хүсэлтээ Эрх бүхий этгээд болон Зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

**Концесс, концессын зүйлийг бусдад шилжүүлэх:**

- 3.23. Концесс эзэмшигч нь өөрийн эрх, үүргээ бусдад шилжүүлэхээр бол Эрх бүхий этгээдээс заавал зөвшөөрөл авсан байна.
- 3.24. Концесс эзэмшигч нь Эрх бүхий этгээдээс зөвшөөрөл авахдаа шилжүүлэн авах сонирхолтой хуулийн этгээдийн техникийн болон санхүүгийн чадварын мэдээллийг нотлох баримтын хамт ирүүлсэн байна.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.**


**КОНЦЕССЫН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ,  
ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ, СӨРӨГ НӨЛӨӨ БҮХИЙ АРГА ХЭМЖЭЭ**

**Концессын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих:**

- 4.1. Эрх бүхий этгээд нь энэхүү Гэрээний хэрэгжилтэд хяналт тавина.
- 4.2. Зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон бусад төрийн захиргааны байгууллагууд, “Эрдэнэс Монгол” ХХК нь холбогдох хууль тогтоожийн хүрээнд энэхүү Гэрээний хэрэгжилтэд хяналт тавина.
- 4.3. Эрх бүхий этгээд нь жил тутамд концесс эзэмшигчийн гэрээний гүйцэтгэлд хяналт тавьж, үнэлгээ хийж дүгнэлт гаргана.
- 4.4. Концесс эзэмшигчийн гүйцэтгэлийн үнэлгээнд зөрчил илэрсэн тохиолдолд Эрх бүхий этгээд нь концесс эзэмшигчийн зөрчлийг арилгах хугацаа заасан мэдэгдлийг хүргүүлнэ.
- 4.5. Концесс эзэмшигч нь энэхүү Гэрээний хэрэгжилтийн явцын талаарх тайлан мэдээ, санхүүгийн тайланг улирал тутам Эрх бүхий этгээд болон зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх үүрэгтэй.
- 4.6. Концесс эзэмшигч нь зам ашиглах явцад тээвэрлэлтийн аюулгүй байдал, машин механизмын ашиглалтын хэм хэмжээ, нүүрс тээвэрлэх хүнд даацын тээврийн хэрэгслийн ачилтын хэмжээ нь заасан стандартад нийцэж байгаа эсэхэд урт хугацаагаар хяналт, зохицуулалт хийх чанарын хяналтын хэлтсийг байгуулан ажиллана. Чанарын хяналтын хэлтэс нь тогтсон хугацаанд ашиглалтын явцад үүсч магадгүй сөрөг нөлөө бүхий арга хэмжээг багасгах арга хэмжээ авна.
- 4.7. Эрх бүхий этгээд нь ашиглалтын хугацааны аль ч үед ашиглалтын үйл ажиллагаа нь энэхүү Гэрээний дагуу явагдаж байгаа эсэхийг шалгах болон бусад зорилгоор гүйцэтгэлийн хяналтыг хийж болно.

**Бие даасан инженер**

- 4.8. Концесс эзэмшигч нь авто замын хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиглэлээр мэргэшсэн, туршлагатай, тусгай зөвшөөрөлтэй гурван хуулийн этгээдийн жагсаалтыг гаргаж Эрх бүхий этгээдтэй зөвшилцэж, нэг этгээдийг сонгож томилно.
- 4.9. Бие даасан инженерийн гэрээг Эрх бүхий этгээд, Зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, концесс эзэмшигч, Бие даасан инженер гэсэн талуудыг оролцуулан байгуулна.



- 4.10. Бие даасан инженерийн ажлын хөлсийг концесс эзэмшигч бүрэн хариуцна.
- 4.11. Бие даасан инженер нь улирал бүр авто замын ажлын гүйцэтгэлийн тайланг гаргаж Эрх бүхий этгээд болон Зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. Хэрэв Эрх бүхий этгээд эсхүл концесс эзэмшигчийн зүгээс бие даасан инженерийг өөрийн үүргээ шударга, зохистой хэмжээгээр, хүчин чармайлт гарган гүйцэтгэхгүй байна гэж үзэх үндэслэлтэй шалтгаан байвал концесс эзэмшигч нь Эрх бүхий этгээдэд бие даасан инженерийн гэрээг цуцлах саналаа хүргүүлж болох бөгөөд Эрх бүхий этгээд нь саналыг судлан үзэж шийдвэрийг гаргана.
- 4.12. Энэхүү Гэрээгээр зохицуулаагүй бие даасан инженерийн эрх зүйн байдлыг бие даасан инженерийн гэрээгээр нарийвчлан зохицуулна.
- 4.13. Хэрэв гэрээний талууд нь бие даасан инженерийн аливаа зөвлөгөө, заавар, шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд бие даасан инженерийн гэрээнд заасан маргаан шийдвэрлэх журмын дагуу шийдвэрлэнэ.
- 4.14. Талууд концессын зүйлийг барих үйл ажиллагаанд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Бие даасан инженерээр дамжуулан өөрчлөлт оруулах тухай мэдэгдлийг хэдийд ч гаргах эрхтэй.
- 4.15. Концесс эзэмшигч нь энэхүү Гэрээний хугацааны туршид Бие даасан инженер болон Зохицуулах байгууллагаар зөвшөөрөгдвэл:
- 4.15.1. Барилгын ажлын дуусах хугацааг түргэтгэх,
  - 4.15.2. Ажлыг гүйцэтгэх, засвар үйлчилгээ хийх, ашиглахтай холбогдон концесс эзэмшигчээс гарах зардлыг бууруулах эсвэл өсгөх,
  - 4.15.3. Гүйцэтгэсэн ажлын үр ашгийг дээшлүүлж, төслийн үнэлээмжийг нэмэгдүүлэх,
  - 4.15.4. Авто замын барилгын ажлын хугацааг сунгах буюу богиносгох зэрэг шийдэлд хүрэх.
- 4.16. Өөрчлөлт оруулах тухай мэдэгдлийг хүлээн авсан тал ажлын 30 өдрийн дотор шаардлагатай мэдээллийг доорх нөхцөлүүдийг тусгасан баримтуудын хамт Бие даасан инженерт хүргүүлнэ. Үүнд:
- 4.16.1. Санал болгож буй зураг төсөл боловсруулах ба барих ажлын зардлын болон бусад өөрчлөлтийг гүйцэтгэх ажлын төлөвлөгөө;
  - 4.16.2. Барилгын ажлыг дуусгахаас өмнө өөрчлөлт оруулахаар бол Барилгын ажлын үе шатны ажлын төлөвлөгөөнд өөрчлөлтийн үзүүлэх нөлөө, гүйцэтгэх ажил ихэссэн эсхүл багассантай холбогдуулан гарах нэмэлт болон хэмнэлтийн зардлын тооцоо, судалгаа;
  - 4.16.3. Бусад шаардлагатай гэж үзсэн бичиг баримтууд зэрэг болно.
- 4.17. Бие даасан инженер нь талуудын ирүүлсэн мэдээллийг нягтлан, өөрчлөлт нь ажлын чанар гүйцэтгэлд болон Төслийн ашигт ажиллагааны байдалд хэрхэн нөлөөлөх, шаардлагатай бол үнийн саналыг шалгаж, өөрчлөлтөөс үүдэн Концесс эзэмшигчээс гарах нэмэлт болон хэмнэлтийн зардлын хэмжээг тогтоож дүгнэлт гаргана.
- 4.18. Бие даасан инженер нь Талуудаас энэхүү гэрээний 4.17-д дурдагдсан мэдээллийг хүлээж авснаас хойш 30 өдрийн дотор өөрийн дүгнэлтийг талуудад хүргүүлнэ.
- 4.19. Эрх бүхий этгээд нь Бие даасан инженерийн дүгнэлтийг үндэслэн өөрчлөлтийг хүлээн авахаар шийдвэрлэсэн тохиолдолд өөрчлөлтийн нөхцөлүүдийг баталгаажуулж, Бие даасан инженерийн дүгнэлтийг ирүүлсэн өдрөөс хойш 30 өдрийн дотор тохирох шийдвэрийг гарган шаардлагатай тохиолдолд концессын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна.
- 4.20. Бие даасан инженер нь өөрийн дүгнэлтийн үнэн, зөв эсэхэд бүрэн хариуцлага хүлээх бөгөөд тухайн дүгнэлтээс үүдэн гарах эрсдэл, хохирлыг хариуцана.

УХА0588  
6098177  
1116127253

## Сөрөг нөлөө бүхий арга хэмжээ

- 4.21. Дараах тохиолдуудыг сөрөг нөлөө бүхий арга хэмжээ гэж үзнэ. Үүнд:
- 4.21.1. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт орсноос болж концесс эзэмшигч энэхүү гэрээ болон нэмэлт гэрээнүүдийн дагуу хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэх боломжгүй болсон.
  - 4.21.2. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт орсноос болж концесс эзэмшигчийн эдийн засгийн чадавхид сөрөг нөлөө үзүүлж, зардлыг нэмэгдүүлж эсвэл орлогыг бууруулахад хүргэсэн;
- 4.22. Сөрөг нөлөө бүхий арга хэмжээ нь концесс эзэмшигчийн энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг хязгаарлаж, сөргөөр нөлөөлсөн нь батлагдсан тохиолдолд концесс эзэмшигч Гэрээний үүргээ зөрчсөн гэж үзэхгүй.
- 4.23. Энэхүү Гэрээний 4.21-д заасан сөрөг нөлөө бүхий арга хэмжээ бий болж концесс эзэмшигчийн орлого буурсан нь батлагдсан бол тухайн буурсан орлогыг нөхөх зорилгоор энэхүү Гэрээний хугацааг Эрх бүхий этгээд нь сунгаж болно.

### Давагдашгүй хүчин зүйл:

- 4.24. Давагдашгүй хүчин зүйл гэдэгт энэхүү Гэрээний 1.1.9 дэх заалтад “Давагдашгүй хүчин зүйл” гэж тодорхойлсон үйл явдлыг ойлгоно.
- 4.25. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас энэхүү Гэрээний тал нь энэхүү Гэрээгээр хүлээсэн аливаа эсхүл бүх үүргээ бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн биелүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлж чадаагүйгээс үүссэн үр дагаврыг тухайн тал хариуцахгүй. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлж чадаагүй нөхцөл байдлыг Гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн гэж үзэхгүй бөгөөд түүний үргэлжлэх хугацаанд тухайн үүргийн гүйцэтгэл болон цаг хугацааны шаардлагыг түр зогссон гэж үзнэ.
- 4.26. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүргээ биелүүлж чадахгүй болсон Тал нь энэ тухайгаа болон түүний шалтгааныг нөгөө Талдаа бичгээр аль болох шуурхай мэдэгдэх бөгөөд Талууд боломжтой бүхий л арга хэмжээг авахын зэрэгцээ харилцан тохиролцож, шалтгааныг арилгахын төлөө хамтран ажиллана.
- 4.27. Энэхүү Гэрээний аль нэг тал нь нь Давагдашгүй хүчин зүйлийн улмаас энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн биелүүлээгүй, эсхүл хойшиулсан тохиолдолд тухайн давагдашгүй хүчин зүйлийн үр дагаврыг арилгахад бодитойгоор шаардагдах боломжит хугацаа болон тухайн ажлыг эхлүүлэх буюу үргэлжлүүлэхэд шаардагдах бэлтгэл ажлын боломжит хугацааг энэхүү Гэрээнд уг ажлыг гүйцэтгэхээр заасан буюу бусад хэлбэрээр зөвшөөрөгдсөн хугацаан дээр нэмж тооцохын зэрэгцээ Гэрээний хугацааг мөн энэ хугацаагаар сунгана.

### ТАВДУГААР БҮЛЭГ. КОНЦЕССЫН ГЭРЭЭГ СУНГАХ, НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ДУУСГАВАР БОЛОХ ЦУЦЛАХ, ХАРИУЦЛАГА

- 5.1. Концессын гэрээний хугацааг Эрх бүхий этгээд дараах тохиолдолд сунгана. Үүнд:
- 5.1.1. Гэнэтийн буюу давагдашгүй хүчиний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас концессын гэрээнд заасан үйл ажиллагаа тасалдсан, хойшлогдсон;
  - 5.1.2. Гэрээтэй холбоотой төрийн байгууллагаас гаргасан үйлдэл, эс үйлдэхүүн улмаас концессын гэрээнд заасан үйл ажиллагаа тасалдсан, хойшлогдсон, зогссон;

УХА0588  
6098177  
1116127253

- 5.1.3. Эрх бүхий этгээдийн концессын гэрээнд тусгагдаагүй хүсэлт, шаардлага нь Концесс эзэмшигчийн зардлыг өсгөхөд хүргэсэн бөгөөд Концесс эзэмшигч гэрээний хугацааг сунгалгүйгээр тухайн зардлыг нөхөх боломжгүй болсон;
- 5.1.4. Концесс эзэмшигчээс шалтгаалахгүй нөхцөл байдлын улмаас гэрээний хугацаанд хөрөнгө оруулалтаяа нөхөн авах боломжгүй болсон.
- 5.2. Концесс эзэмшигчид санхүүгийн үр дагавар үүсгэх, эсхүл нийтэд хэт өндөр үнэ тариф, төлбөр ногдуулахад хүргэх урьдчилан тооцоогүй нөхцөл байдал үүссэн үед концессын гэрээг Эрх бүхий этгээд сунгана.

**Концессын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах:**


- 5.3. Гэрээний талууд харилцан тохиролцож концессын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 5.4. Энэхүү Гэрээний хугацаа сунгасан тухай нэмэлтийг гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэрээр байгуулах бөгөөд оруулсан нэмэлт өөрчлөлт нь гэрээний адил хүчин төгөлдөр байна.
- 5.5. Энэхүү Гэрээнд хийсэн бүхий л нэмэлт, өөрчлөлт болон хувилбарууд нь бичгэн хэлбэрээр, тал тус бүрийн эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурсан тохиолдолд хүчинтэй болно.

**Концессын гэрээ дуусгавар болох, гэрээг цуцлах:**

- 5.6. Дараах тохиолдолд концессын гэрээ дуусгавар болно:
  - 5.6.1. Талууд харилцан тохиролцсон;
  - 5.6.2. Энэхүү Гэрээний хугацаа дууссан бөгөөд гэрээг сунгаагүй;
  - 5.6.3. Концесс эзэмшигч дампуурсан буюу татан буугдсан;
  - 5.6.4. Концессын тухай хууль болон Концессын гэрээнд заасны дагуу гэрээг цуцалсан.

**Эрх бүхий этгээдийн санаачилгаар гэрээг цуцлах:**

- 5.7. Концессын гэрээг дараах тохиолдолд Эрх бүхий этгээдийн санаачилгаар цуцална:
  - 5.7.1. Концесс эзэмшигч нь уралдаант шалгаруулалтад оролцохдоо хууль зөрчсөн буюу хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь шүүхээр тогтоогдсон;
  - 5.7.2. Концесс эзэмшигч нь Монгол Улсын хууль тогтоомжийг удаа дараа буюу ноцтой зөрчсөнийг эрх бүхий байгууллага тогтоосон ;
  - 5.7.3. Концесс эзэмшигч концессын гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн эсхүл Энэхүү гэрээнд заасан хориглосон үйл ажиллагааг явуулсан нь гэрээнд зааснаар гэрээг цуцлах үндэслэл болсон;
  - 5.7.4. Үндэsnий аюулгүй байдал, батлан хамгаалах болон нийтийн эрх ашгийн үүднээс Концессын гэрээг цуцлахаар Засгийн газар шийдвэрлэсэн;
  - 5.7.5. Концессын гэрээнд зааснаас бусад тохиолдолд Концесс эзэмшигчийн хувьцааны хяналтын багцыг Эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлсэн;
  - 5.7.6. Эрх бүхий этгээд Концесс эзэмшигчид удаа дараа зөрчлийг арилгах тухай үндэслэл бүхий хугацаатай мэдэгдэл хүргүүлэхэд Концесс эзэмшигч хугацаандаа холбогдох арга хэмжээг авч зөрчлийг арилгаагүй бол Энэхүү гэрээг дангаар цуцлах;
  - 5.7.7. Концесс эзэмшигч дампуурсан буюу татан буугдсан.



## **Концесс эзэмшигчийн санаачлагаар гэрээг цуцлах:**

- 5.8. Концессын гэрээг дараах тохиолдолд концесс эзэмшигчийн санаачилгаар цуцална.  
Үүнд:
  - 5.8.1. Эрх бүхий этгээд буюу Зохицуулах байгууллага концессын гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй;
  - 5.8.2. Засгийн газар болон эрх бүхий төрийн байгууллагаас концессын эрхийг хууль бусаар хүчингүй болгосон.
- 5.9. Концессын гэрээг цуцлахад талуудад олгох нөхөх олговрыг тооцоолоходоо концессын гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлын зохих үнэ цэнэ, гарсан зардал, тухайн талд учирсан бодит хохирол зэргийг харгалзан үзнэ.
- 5.10. Энэхүү гэрээ дуусгавар болсноор концессын зүйлийг эзэмших, ашиглах, захиран зарцуулахтай холбогдох эрх төрийн өмчийн, эсхүл орон нутгийн өмчийн асуудал эрхэлсэн холбогдох этгээдэд шилжинэ.
- 5.11. Талууд гэрээнд заасан үндэслэлээр гэрээ цуцлах тохиолдолд нөгөө талдаа 3 сарын өмнө албан бичгээр мэдэгдсэн байна.

## **Концессын гэрээг цуцалсны улмаас нөхөх олговор олгох:**

- 5.12. Энэхүү Гэрээний 5.8 дахь заалтад заасан үндэслэлүүдийн дагуу концесс эзэмшигчийн санаачлагаар гэрээ цуцлагдах тохиолдолд нөхөх олговор олгоно.
- 5.13. Энэхүү гэрээний 5.12-т заасан нөхөх олговрын хэмжээг Концессын тухай хуулийн 24.4-т заасныг баримтлан Эрх бүхий этгээдээс байгуулсан комисс ажиллан тогтоо ба ингэхдээ концессын гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлын зохих үнэ цэнэ, гарсан зардал, тухайн талд учирсан бодит хохирол, үүний дотор шаардлагатай тохиолдолд олох боломжтой байсан ашиг зэргийг оруулан тооцож болно.

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ**

- 6.1. Концессын гэрээний талуудын хооронд үүссэн аливаа маргааныг гэрээгээр харилцан тохиролцсон аргаар шийдвэрлэнэ.
- 6.2. Эрх бүхий этгээд нь халдашгүй дархан эрхээ маргаан шийдвэрлэх ажиллагаанд давуу эрх болгон ашиглахгүй болно.
- 6.3. Концесс эзэмшигч, өөрийн хувьцаа эзэмшигч, концессыг санхүүжүүлэгч болон аж ахуйн үйл ажиллагааных нь хувьд хамтран ажиллаж байгаа бусад этгээдийн хооронд үүссэн маргааныг тэдгээрийн харилцан тохиролцсон аргаар шийдвэрлэнэ.
- 6.4. Концессын гэрээнд заасан үйл ажиллагаатай нь холбогдуулж концесс эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг арбитрын хэлэлцээртэй бол арбитрын журмаар, бусад тохиолдолд Монгол Улсын шүүхээр шийдвэрлэнэ.
- 6.5. Энэхүү гэрээнээс үүдэн гарах аливаа маргааныг шийдвэрлэхдээ Монгол Улсын хууль тогтоомжийг дагаж мөрднө.
- 6.6. Эрх бүхий этгээд болон Концесс эзэмшигчийн хооронд аливаа маргаан үүсэх тохиолдолд талууд маргааныг эв зүйгээр шийдвэрлэхийг зорино.
- 6.7. Талууд маргааныг энэхүү Гэрээний 6.6-д зааснаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Хонг Конгийн Олон Улсын Арбитрын Төвөөр /HKIAC/ шийдвэрлүүлнэ.
- 6.8. Энэхүү Гэрээгээр талуудын хооронд төсөлтэй холбогдуулан үүссэн бүхий л асуудлуудыг болон гэрээний харилцааг зохицуулна. Энэхүү Гэрээ болон талуудад

УХА0588  
6098177  
1116127253

- үйлчилж буй аливаа нэмэлт гэрээ хоорондоо зөрчилдөх тохиолдолд энэхүү Гэрээ давамгай үйлчилнэ.
- 6.9. Энэхүү Гэрээний агуулгатай зөрчилдөх тохиолдолд дараах дэс дарааллыг баримтална.
- 6.9.1. Энэхүү Гэрээ;
  - 6.9.2. Уралдаант шалгаруулалтын бичиг баримт болон хавсралт;
  - 6.9.3. Төслийн Техник, эдийн засгийн үндэслэл;

#### **Хууль тогтоомж өөрчлөгдөх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээ**

- 6.10. Концесс эзэмшигч нь Энэхүү гэрээний хугацаанд холбогдох хууль тогтоомжид орсон өөрчлөлт нь төслийн хэрэгжилтэд тааламжтай нөхцөл олгож байгаа гэж үзсэн тохиолдолд Эрх бүхий этгээдэд санал гарган Иргэний хуулийн 5.3 дахь заалтын дагуу гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна.
- 6.11. Энэхүү гэрээний хугацаанд хууль тогтоомж өөрчлөгдсөнөөс Энэхүү гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай болсон тохиолдолд Монгол Улсын Иргэний хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг баримтлан Концесс эзэмшигчийн эрх ашиг, сонирхлыг дордуулсан аливаа өөрчлөлт оруулахгүй.

#### **ДОЛДУГААР БҮЛЭГ. НУУЦЛАЛ, БУСАД ЗҮЙЛС**

##### **Нууцлал**

- 7.1 Тал тус бүр холбогдох хууль тогтоомжийн дагуу энэхүү Гэрээ, төслийн үйл ажиллагаатай холбоотой бүх мэдээлэл, тоо мэдээ болон бусад бүртгэлийн нууцлалыг хангах ба энэхүү Гэрээ цуцалсан тохиолдолд Эрх бүхий этгээдийн энэхүү баримт бичгүүд, мэдээллийг ашиглаж хэрэглэх эсхүл аливаа Зээлийн гэрээний дагуу мэдээлэл авах Зээлдүүлэгчдийн болон бусад этгээдийн эдгээр баримт, мэдээллийг ашиглах эрх энэхүү энэ заалтаар хязгаарлагдахгүй. Аль ч тохиолдолд дээр дурдсан эрхүүд нь зөвхөн Концессын эрхийг ашиглах, засвар үйлчилгээ хийхтэй холбоотой ажлуудад ашиглагдана.

##### **Бусад зүйлс**

- 7.2 Энэхүү Гэрээнд хийсэн бүхий л нэмэлт, өөрчлөлт болон хувилбарууд нь бичгэн хэлбэрээр, тал тус бүрийн эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурсан тохиолдолд хүчинтэй болно.
- 7.3 Энэхүү гэрээнд дурдагдсан аливаа мэдэгдэлийг дараах хаягаар хүргүүлнэ:

**Эрх бүхий этгээд:** Засгийн газрын тохируулагч агентлаг, Үндэсний хөгжлийн газар

**Хаяг:** Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн Үндэстний Гудамж 5/1

**Засгийн газрын II байр**

**Факс:** 263333

**Утас:** 264926

**Цахим хаяг:** info@nda.gov.mn

**Концесс эзэмшигч:** Тал нутгийн хөгжлийн зам ХХК

**Хаяг:** Хан-Уул, 15-р хороо, Зайсан,,, 14 тоот

**Факс:**

**Утас:** 88111403



### **Цахим хаяг:**

Талуудын аль аль нь Монгол Улс дахь хаягаа өөрчлөхөөр бол нөгөө Талдаа мэдэгдэл хүргүүлснээр өөрчилж болно.

- 7.4 Энэхүү төслийн инженерийн зураг төсөл, техникийн шаардлага, ажлын тоо хэмжээ, барилгын ажлын болон төслийн нийт төсөв гэх мэт хавсралтууд нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.
- 7.5 Энэхүү Гэрээний аль нэг зүйл заалт хүчингүй болох нь гэрээний бусад зүйл, заалтын буюу гэрээний хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй болно.
- 7.6 Энэхүү гэрээг Талууд 4 хувь Монгол хэл дээр үйлдсэн бөгөөд хувиуд нэгэн адил хүчинтэй байна.

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ  
АГЕНТЛАГҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН  
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖИ**

Гарын үсэг  


Газрын дарга: Б.Баярсайхан

Тамга

**“ТАЛ НУТГИЙН ХӨГЖЛИЙН ЗАМ” ХХК-  
ИЙГ ТӨЛӨӨЛЖИ**

Улаанбаатар хот  
Гарын үсэг  


Гүйцэтгэх замжигалт Б.Батор-Эрдэнэ

Тамга

## **ХАВСРАЛТУУД**

Нэгдүгээр хавсралт- Авто замын батлагдсан зураг төсөл  
Хоёрдугаар хавсралт- Авто замын техник, эдийн засгийн үндэслэл  
Гуравдугаар хавсралт- Төслийн компанийн дүрэм, гэрчилгээ, хувьцаа эзэмшигчдийн гэрээ  
Дөрөвдүгээр хавсралт- Төслийн санхүүжилтийн гэрээ  
Тавдугаар хавсралт-Авто замын барилгын ажил гүйцэтгэх гэрээ  
Зургадугаар хавсралт- Бие даасан инженерийн гэрээ  
Долдугаар хавсралт- Даатгалын гэрээ  
Наймдугаар хавсралт- Барилгын ажлын төлөвлөгөө  
Есдүгээр хавсралт- Авто замын засвар арчлалт, их засварын төлөвлөгөө  
Аравдугаар хавсралт- Авто замыг шилжүүлэн өгөх төлөвлөгөө

---000---

